

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

**КАМПУЧИЙН ХУВЬСГАЛЫН ЭРГЭЛТ БУЦАЛТГҮЙ
ҮЙЛ ЯВЦ
(Ардын хувьсгалын нь 5 жилийн ойд)****Д. Баярхүү**

Кампучийн ард түмэн гадны халдан түрэмгийллийг няцааж, америкийн империализмын колоничлолын олон жилийн дайны сүйрэл, полпотын аймаглан устгагч дэглэмийн уршиг дагаврыг ардын хувьсгалт нам, бүх нийтийн сонгуулиар сонгогдсон ардын засгийн газрынхаа удирдлагаар амжилттай арилгаж, шинэ амьдралаа зохиох замаар хэлбэрэлтгүй замнаж байна.

1979 оны нэгдүгээр сард эх орноо Пол Пот-Иенг Сари-Кхиеу Самфаны цуст дэглэмээс чөлөөлсний дараа өнгөрсөн таван жилд Кампучийн ард түмэн эвдэрч сүйдсэн улс ардын аж ахуй, соёлоо өөрийн дайчин манлай-КАХН-ын удирдлагын дор, Зөвлөлт Холбоот Улс, Вьетнам, ах дүү социалист бусад орны тусламжийн ачаар богино хугацаанд сэргээн босголоо.

БНКАУ-д хэрэгжиж байгаа нийгэм-эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөн байгуулалтыг 1981 онд хуралдсан КАХН-ын IV их хурал бататгаж, улмаар тус оронд цоо шинэ нийгэм болох социализмын үндэс байгуулах лут том зорилтыг төлөвлөн заасан билээ. «Кампучийн хувьсгал бол дэлхийн хувьсгалын нэг бүрэлдэхүүн хэсэг. БНКАУ бол социалист орнуудын гэр бүлийн гишүүн. БНКАУ марксизм-ленинизм пролетарийн интернационализмын зарчим дээр социалист ажилчин дээр социалист хамтын нөхөрлөл, олон улсын коммунист ажилчны хөдөлгөөнтэй нэгдэл нягтралаа хойшид ч бэхжүүлэх болно»¹ гэж их хурлын баримт бичигт онцлон тэмдэглэсэн юм.

БНКАУ-ын хөгжлийг илтгэсэн хэд хэдэн тоо баримт дурдъя. БНКАУ, чөлөөлөгдсөнийхөө дараа эхний жилүүдэд цагаан будааны (тутрага) дөнгөж 700 мянган га талбай боловсруулж байсан бол одоо 2 сая илүү га талбай боловсруулж, техникийн таримал 1983 онд 1981 оныхтой харцуулбал хоёр дахин нэмэгдэж, 42700 га болжээ.

Үндсэндээ хөдөө аж ахуйд тулгуурлаж байгаа үндэсний эдийн засгийг хөгжүүлэхэд зайлшгүй чухал байгаа услалт, усжуулалтын систем, каучукийн тариаланг хөгжүүлэхэд ихээхэн анхаарал тавьж, ингэснээр тус оронд каучукийн тарималын талбай 11800 га-д хүрчээ.² БНКАУ бол хөдөө аж ахуйн орон юм. Хөдөө аж ахуйг төлөвлөгөөтэйгээр өөрчлөн байгуулах асуудлыг КАХН гол зорилтоо болгон дэвшүүлээд ийм зорилтын үүднээс 1981—1985 оны таван жилд тариалангийн талбайг 2 сая 300 мянгаас 2 сая 500 мянган га-д хүрэх, мал аж ахуйг үндсэнд нь бүрдүүлдэг үхэр сүргийн тоо толгой 1,4—1,5 саяд хүртэл

¹ «Правда» 30. V. 1981.

² «Новое время» № 34, 1983.

өсгөхөөр төлөвлөсөн байна.² Өнгөрсөн таван жилд кампучийн хөдөө аж ахуйн хөдөлмөрийн харилцан туслах нөхөрлөлийн материал-техникийн бааз үлэмж өсч, зохион байгуулалтын талаар бэхжив. Одоо хөдөлмөрийн харилцан туслах нөхөрлөлийн тоо 90 мянгаас давж, тэдгээрт 1 сая 350 мянган тариачин айл өрх хамрагдаж байна.⁴ Намаас тус орны эдийн засгийг сэргээн босгох талаар авсан дээрх арга хэмжээний үр дүнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хамарсан улсын сектор бүрэлдэн төлөвшиж байна.

Аж үйлдвэрийн салбар ч мэдэгдэхүйц хөгжин бэхжиж, нэхмэл, хүнсний үйлдвэрлэл илүү хурдацтай хөгжиж байна. Кампучийн үндэсний аж үйлдвэрийг сэргээн хөгжүүлэхэд Зөвлөлт Холбоот Улс үнэлж баршгүй тусламж үзүүлж байна. Өнгөрөгч жилүүд бол ЗСБНХУ, БНКАУ-ын хувьд хоёр талын худалдаа-эдийн засгийн харилцаа ихээхэн өргөжин гүзгийрсэн, үйлдвэр, тээвэр, холбоо, цахилгаан эрчим хүч болон бусад салбарт хамтын ажиллагаа үр бүтээлтэй хөгжсөн жилүүд байлаа. Пномпень хотод дизель хөдөлгүүрт цахилгаан станц барих талаар 1983 онд ихээхэн ажил хийж, одоо станцын тоног төхөөрөмжийг угсарч дуусч байна. Станц ашиглалтад орсноор 1984 онд Кампучийн нийслэлийн эрчим хүчний хангамж үлэмж сайжирч, хотын цахилгаан станцуудын нийт хүч чадал 70 хувиар нэмэгдэх юм. Зөвлөлтийн техник мэргэжилтний тусламжаар 1983 онд 50 километр зам сэргээн засварлаж, 500 метр гүүр тавив. Тус оронд аж үйлдвэрийг хөгжүүлэх нэг нөхцөл бол инженер техникийн мэдлэгтэй үндэстний боловсон хүчин бэлтгэх явдал нь мэдээж билээ. Үйлдвэрийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх гол төв—Пномпений техникийн дээд сургуулийг сэргээх ажил дуусжээ. 1983—1984 оны хичээлийн жилд тус сургуульд инженер техникийн мэргэжлээр 1000 гаруй оюутан суралцаж байгаа нь урьд өмнө байгаагүй олон юм. Дээд сургуулийн лабораториудыг орчин үеийн шинжлэх ухаан-техникийн багажаар дахин тоноглох талаар кампучийн мэргэжилтнүүд зөвлөлт нөхөдтэйгээ мөр зэрэгцэн ажиллаж байна. Одоо БНКАУ-д янз бүрийн 300 орчим үйлдвэрийн газар, түүний дотор 60 фабрик, завод ажиллаж, бүтээгдэхүүнээ гаргаж,⁵ төмөр зам, авто тээвэр бүрэн бүтэн хэвийн ажиллагаанд оржээ.

Кампучийн ардын хувьсгалын таван жилд олсон томоохон ололт амжилт бол ардын боловсрол, соёл, эрүүлийг хамгаалах салбарын гялалзам амжилт мөн. Ардын хувьсгалын жилүүдэд 100 мянган кампучи хүн уншиж бичиж сурлаа. Одоо тус орны бүх нутагт бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах курс ажиллаж, түүнийг төгсөгчид жилээс жилд нэмэгдэж байна. 1982—1983 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын бага дунд сургуульд 1,7 сая хүүхэд суралцаж, ЗСБНХУ, Вьетнам, ах дүү бусад оронд янз бүрийн мэргэжилээр 2000 гаруй залуус суралцаж байна. 1983—1984 оны хичээлийн жилд тус орны янз бүрийн шатны 3000 гаруй сургуульд мэргэжилийн 30 мянган багш ажиллаж, нэг сая 840 мянган хүүхэд суралцаж байна.⁶ БНКАУ-ын нийгэм-эдийн засаг, соёлыг хөгжүүлэх зорилттой холбогдон бүх нийтийг бичиг үсэгтэй болгох чухал бөгөөд хариуцлагатай үйлсэд оюутнууд, ардын армийн дайчид, боловсролтой бүх хүмүүс идэвхтэй оролцож байгаа тухай Ардын боловсролын Яамны сайд Пен Навут бичиг

³ «Улаан од» 1984.1.6

⁴ Мөн тэнд.

⁵ «Новое время» № 9, 1982.

⁶ «Үнэн» 1983. XI. 20

үсэг үл мэдэх явдлыг арилгах ажлыг удирдах төв газрын хуралдаан дээр тэмдэглэсэн байна.

Эрүүлийг хамгаалах салбарт том амжилт болов. Полпотын заналчид тус орноос зайлж одсоны дараа ердөө гуравхан эмч амьд мэнд үлдэж, 594 их эмч, эмнэлгийн ажилтан амь үрэгдсэн байлаа. Тэгвэл одоо БНКАУ-д 1200 гаруй их, бага эмч, сувилагч ажиллаж байгаа нь ардын засгийн жилүүдэд хүн амын эрүүлийг хамгаадах талаар их анхаарч ирсний үр дүн юм.⁷ Бүгд Найрамдах улсын хамгийн томоохон больниц болох Пномпений төв госпиталийг сэргээх ажил дуусч, 1983 онд 100 гаруй мянган хүнд эмнэлгийн тусламж үзүүлжээ. Соёл урлаг ч мөн мэдэгдэхүйц хөгжиж тус оронд ардын хөгжмийн 750 амтлаг, ардын дуу бүжгийн 30 ансамбль байгуулагдан ажиллаж байна⁸. Театр, кино урлаг, уран зохиол дахин сэргэн хөгжих эхлэл тавигдаж, энэ талаар ардын засаг ихээхэн анхаарал тавьж байна.

Кампучийн нийгэм-эдийн засгийн хөгжлийг илтгэн харуулах өдий төдий олон баримтын дотроос зөвхөн хэдийг энд дурдав. Энэ үзүүлэлтүүд бол Кампучийн хувьсгалын бахархал мөн бөгөөд КАХН-ын IV их хурлаас тус оронд социализмын үндэс байгуулах талаар заасан нийгэм-эдийн засгийн программд чухал зүйл болж байгаа юм.

БНКАУ дахь нийгэм-улс төр, эдийн засгийн өсөлт хөгжилтөд КАХН, БНКАУ-ын ардын засгийн энх тайванч гадаад бодлого чухал үүрэгтэй юм. БНКАУ-ын олон улсын нэр хүнд байнга өсч байна. Дэлхийн 30 гаруй улс орон, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний байгууллага тус улсыг хүлээн зөвшөөрч, тусгаар тогтнол, энх тайван, эвсэлд үл нэгдэх гадаад бодлогыг нь дэвшилт олон нийт талархан дэмжиж байна. ЗСБНХУ, социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой тогтоосон найрамдал, хамтын ажиллагаа бол БНКАУ-ын энх тайванч гадаад бодлогын ололт амжилтын баталгаа юм. БНКАУ даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, зэвсгийг бүх нийтээр бүрэн хурааж, цөмийн дайны аюулыг зайлуулахын төлөө тууштай тэмцэж, энэ тэмцэлд хувь нэмрээ оруулсаар байна.

БНКАУ Зүүн өмнөд Азийн нэг орон учраас Энэтхэг-хятадын хойгийн ах дүү Вьетнам, Лаос улстай бүс нутгийн энх тайвны төлөө уялдуулан зохицуулсан, харилцан тохиролцон, системтэй, үр бүтээлтэй тэмцэл хийж байгаа нь тодорхой юм. БНКАУ, БНСВУ, БНАЛАУ-ын нам, төрийн удирдагчдын дээд хэмжээний зөвлөлгөөн, Гадаад явдлын Яамны сайд нарын удаа дараагийн бага хурал, ах дүү гурван орны энхийг эрхэмлэгч бодлого, хамтын тэмцлийн хувьсгалт уламжлалыг нотлон харуулсан улс төрийн чухал үйл явдал болсон юм. Эдгээр уулзалт, бага хурал дээр БНКАУ хөрш зэргэлдээ орших Тайландтай сайн хөршийн харилцаа тогтооход чиглэсэн тодорхой саналыг нэг бус удаа дэвшүүлсэн юм. Энэтхэг-хятадын хойгийн орнууд болон Зүүн өмнөд Азийн эвслийн (АСЕАН) орнуудын хооронд, өөрөөр хэлбэл нийгэм-улс төрийн хоёр өөр чиглэлийн хооронд тэгш эрх, харилцан ашигтай байх, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох зарчмын үндсэн дээр яриа хэлэлцээ хийж эхлэх тухай үзэл бодлоо илэрхийлсэн юм. АСЕАН-ы эвсэлд оролцогч зургаан орон эдгээр саналд одоо хир нь нааштай хариу өгөөгүй байгаа боловч түүний ач холбогдол дэлхий дахины байдал түгшүүртэй байгаа өнөө үед нэн чухал хэвээр байгаа юм.

БНКАУ-ын дотоод, гадаад бодлогын ололт амжилтад хорсон бачимдсан олон улсын империализм, эзлэн түрэмгийлэх үзэлт бусад

⁷ «Үнэн» 1984. 1. 6

⁸ «Вьетнам» № 1, 1984.

хүчин хэвлэл мэдээллийн бүхий л хэрэгслээр ардын кампучийг гүтгэн гүжирдэх, нөгөө талаар полпотын дэглэмийг сэргээн амилуулах гэж оролдсоор байгаа нь нэг онцлог болоод байна. Ази тивд төдийгүй даян дэлхийд энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, улс орнуудын хооронд итгэлцэл, өргөн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулах үүрэгтэй БНХАУ-ын эрх баригчид кампучийн хувьсгалт үйл явцыг улайран эсэргүүцэх талаар голлох үүрэг гүйцэтгэж байгаа нь харамсалтай. Улс гүрний үндсэний эрх чөлөөний тэмцлийг жадлан эсэргүүцэхэд чигэлсэн ийм бодлого дэвшилт хүн ардын таашаалыг хүлээж чадахгүй нь мэдээж. Кампучийн талаар БНХАУ-ын баримталж байгаа байр суурь гэгчийг Бээжинд янз бүрээр тайлбарласаар байна. Хятадын албан ёсны дээд хэмжээний төлөөлөгчдийн хийж байгаа мэдэглэл, хэвлэлд нийтлэгдсэн материалууд Кампучийн үнэн байдалтай огт авцалдаагүй байгаа юм.

ХКН-ын Төв Хорооны ерөнхий харийн бичгийн дарга Ху Яобан кампучийн талаар хятадын засгийн газрын баримталж буй албан ёсны байр суурийг тайлбарласан гурван зүйлт мэдэгдэл гэгчээ хэд хэдэн удаа хийсэн юм. Энэ нь «1. Бид кампучийн эх оронч хүчний гурван талын эвслийн засгийн газрыг тууштай дэмжих, 2. Кампучийн нутгаас Вьетнамын бүх цэргийг гаргаж, төвийг сахисан, эвсэлд үл нэгдэх кампучийг байгуулах эрхийг нь хүлээн зөвшөөрүүлэх, 3. Хятад улс кампучид ямар ч хувийн ашиг завшаан харахгүй»⁹ гэсэн зүйлүүд орж байна. Энд Хятад улс Кампучийн талаар ямар ч ашиг завшаан харахгүй гэсэн мэдэгдэл жинхэнэ бодит байдал дээр хэрхэн хэрэгжиж байгааг онцлон авч үзэж болно. Ху Яобан Японы «Майнити симбун» сонины сурвалжлагчтай хятадын гадаад дотоод бодлогын өргөн хүрээтэй асуудлаар ярилцахдаа, Ази тивийн энх тайвныг бусниулагч тогтворгүй хүчин зүйл гэгч сэдвийг зохиомлоор гаргаж, түүндээ Кампучийг нэгдүгээрт оруулан, түүнийгээ Тайвань болон Өмнөд Солонгосын байдалтай хутгаж, нэг байранд тавьсан нь харагдсан юм.¹⁰

Хятадын удирдагчид «Вьетнамд сургамж өгөхийг» дахин санаархаж, хятад-вьетнамын хил дээр зэвсэгт өдөөн хатгалгаа зогсоохгүй байгаагийн зэрэгцээ кхмерийн хувьсгалын эсэргүү хүчийг ивээн тэтгэж, БНХАУ-ын эсрэг цэнэглэн турхирахад бүх талаар туслаж байна.

«Кампучийн эх оронч хүчний гурван талын эвслийг засгийн газар» гэгчийн толгойлогчдыг 1983 оны сүүлээр Бээжинд цуглуулсан нь БНХАУ кампучийн ард түмний сэргэн мандалтын үйл хэргийг саатуулахыг илэрхий оролдож байгааг нь бас дахин харуулсан юм.

«Ардчилсан кампучийн төлөөлөгчид» гэгчийг хятадын нийслэлд төрийн дээд зочны хэмжээнд хүлээн авч, бутцохигдсон полпотчуудад тусламж үзүүлэх хэлэлцээ хийжээ. ХКН-ын Зөвлөхүүдийн Төв Комиссын дарга Дэн Сяопин Кампучийн гурван талын хүчний төлөөлөгчидтэй уулзахдаа, «Та нарийн нягтралыг хятад улс тун хүндэтгэн үзэж байна»¹¹ гэж мэдэгдээд, харамгүй туслан дэмжинэ гэсэн амлалт өгсөн юм. Айлчлал гэгчийн үеэр Бээжинд болсон нэгэн хэвлэлийн бага хурал дээр Сианук үг хэлэхдээ «хүнд зэвсэг, галт хэрэгсэл нийлүүлэх, тусламжаа нэмэгдүүлэхийг хятадаас хүсэхэд нааштай хариу өглөө»¹² гэж мэдэгдсэнээс үзэхэд Тайландын нутагт орогнож байгаа кхмерийн харгис хүчнийхэнд цэргийн тусламж үзүүлэхээ улам идэвхжүүлэх нь

⁹ «Жэньминь жибао» 1983. X. 7

¹⁰ «Жэньминь жибао» 1983. X. 10

¹¹ «Жэньминь жибао» 1983. XII. 25

¹² «Улаан од» 1984. I. 11

тодорхой болсон юм. Сианук нарыг Бээжингээс Тайланд руу буцсаны дараа ч хятадын суртал нэвтрүүлэг «ардчилсан кампучийн» ямар нэг «амжилт» гэгчийг сурталчилсаар байна.

Одоо Кампуч-тайландын хил урьдын адил амар тайвангүй байна. Полпотын дээрэмчидийн бүлгийг Тайландын нутагт эмхлэн байгуулж байгаа нь тодортой юм. Тайланд бол кампучийн хувьсгалын дайсан «Улаан кхмерчууд» гэгчдийг бүр анхнаас нь нутагтаа орогнуулсан. Тэднийг тэтгэж, БНКАУ-ын эсрэг өдөөн хатгалганд хамтран оролцдог орон болоод байгаа юм. Сианукийн мэдлийн 1500 орчим хүн (хаант засгийн түшмэл, феодал, хөрөнгөтөн, тэдний гэр бүлийнхэн), «Кхмерийн үндэсний чөлөөлөх фронт» гэгч Сон Санны 5000 орчим хөлсний алуурчин дээрэмчид, харгис цагаачид, полпотын 20000 зэвсэглэсэн цэрэг, нийтдээ гурван талын 26500 хүн одоо тайландын ширэнгэн ойд орогнож байна.¹³ Хэрэв тайландын эрх баригчид полпотын үлдэгдэл дээрэмчдийг нутаг орондоо «цагаачлахыг» зөвшөөрөөгүй, тэдний ажил явууллага идэвхжих хөрс суурь бий болгож өгөөгүйсэн бол БНКАУ-ын эсрэг хорлон сүйтгэх ажиллагаа хэрэгжих боломжгүй байсан нь тодорхой билээ. Чухамдаа тайландын нутгаар дамжуулан Хятад, АНУ хоёр полпотын дээрэмчдэд мөнгө, зэвсэг, байлдааны техник, хоол хүнс (ихэвчлэн тутрага) эмийн зүйл нийлүүлж байгаа юм. Ийм зорилгодоо тайландын Утапао боомт, Донмыонг, Коратын нисэх онгоцны буудал, кампучийн хилийн ойролцоох стратегийн замыг ашиглаж байна.¹⁴ «Тусламжийн бараа» гэгчийг тайландын цэргийн тээврийн хэрэгслээр Бангкокоос гурван цаг гаруй яваад хүрдэг полпотын бааз байдаг уулархаг районд хүргэдэг байна.

Бангокт байгаа БНХАУ-ын элчин сайдын яам болон хятадын цэргийн атташегийн газар кампучийн эсрэг полпотынхны үйлдэж байгаа түрэмгий дайныг удирдах төв штаб болжээ. Вьетнамын албан ёсны мэдээнээс үзэхэд, тайланд-кампучийн хилийн районд тайландын талд байгаа хятад хүний тоо нийтдээ 20000-д хүрч, полпотын үлдэгдлийг цэргийн эрдэмд сургах, тэднийг зэвсэг, техник, хоол хүнсээр хангах үүрэг гүйцэтгэж байна.¹⁴ Хятадын цэргийн төрөл бүрийн мэргэжлийн зөвлөхүүд, тухайлбал партизаны дайн, тактик, цэргийн тээвэр, тагнуул, сэтгэхүйн дайн, ар тал хангалтаар мэргэжсэн хүмүүс Бангокт улам олноороо үзэгдэх болов. 1979 оноос өмнө Кампучид сууж байсан БНХАУ-ын дипломатууд, тухайлбал элчин сайд байсан Сун Хао, цэргийн атташе байсан Дэн Суншан, хангамжийн ажил хариуцаж байсан Ван Маоцин, эдийн засагч Ли Факуэй нар одоо Бангокт сууж байна.¹⁵ Эд бол чухамдаа полпотын цэргийн үлдэгдлийг туслан дэмжиж тэдний хорлон сүйтгэх ажиллагааг удирдан чиглүүлж байна.

Хятадын түрэмгий санаархал зөвхөн полпотын үлдэгдлийг зэвсэглэн тэтгэж байгаагаар хязгаарлагдахгүй. Бээжингийн суртал нэвтрүүлэг өрнөдийн хорлон сүйтгэх төвүүдтэй хамтран «кампучийн асуудал» гэгч гүжир гүтгэлгийн кампанийг уйгагүй дэвэргэсээр байна. Хятадын олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь БНСВУ, БНКАУ-ын гадаад бодлого, кампучийн хувьсгалын үнэн мөрийг гүжирдэн гуйвуулах талаараа өрнөдийнхний коммунизмын эсрэг, зөвлөлтийн эсрэг суртал нэвтрүүлэгтэй нэгдэн нийлж байгаа нь илт байна. Хятадын өмнөд талын Юньань мужийн Куньмин хотын хавиас «Ардчилсан кампучийн радио-

¹³ «Зарубежом» № 10 (1183) 1983

¹⁴ «Вьетнам» № 1, 1984 г.

¹⁵ «Вьетнам» № 1, 1984 г.

станц нэвтрүүлгээ хийж, түүнийг Иенг Серийн эхнэр Иенг Тхирит гэгч толгойлж, мэдээ материалын эхийг Бээжингээс зохиож өгдөг байна.¹⁶

Кампучийг гүтгэн дайрах явдлыг нэг гол сэдвээ болгосон хятадын хэвлэл радио өөрийн зорилгодоо Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн жил бүрийн ээлжит чуулгануудыг шургуу ашигладаг юм. Тэд яг энэ үеэр «кампучи, афганистаны асуудал» гэгчийг улам их улиглан давтаж, Зөвлөлт Холбоот Улсын болон Вьетнамын энх тайванч гадаад бодлогыг мушгин гуйвуулах кампанийг үргэлжлүүлсээр байна. Бээжингийн хөөрөгдсөөр байгаа «кампучийн асуудал» гэгчийг дэмжигчдийн хүрээ үнэн чанартаа Рейганы засаг захиргаа, түүний дуулгавартай зарц-тайландын харгис дэглэмээр бараг хязгаарлагдаж байна.

БНКАУ-ын энх тайван бүтээн байгуулалтыг тасалдуулах, кампучийн нэр хүндийг олон улсын тавцан дээр бусниулах гэсэн оролдлогоо орхихгүй байгаа БНХАУ, АНУ хоёр «Кампучийн асуудал» гэгчийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1983 оны ээлжит чуулганаар тулган хэлэлцүүлсэн юм. Гэвч ийм оролдлого НҮБ-д, олон улсын хүрээнд ч түүний дотор олон улсын бүх байгууллагад хууль ёсныхоо суудлыг эзлэх ёстой. Кампучийн ард түмний шийдвэртэй эсэргүүцэлтэй тулгарсан юм.

Ийм зохиомол асуудлыг кампучийн ард түмний хууль ёсны төлөөлөгчид оролцоогүй, харин тэдний байр суурийг хэнийг ч төлөөлөөгүй полпотын тоглоомын этгээд эзэлж байсан үед хэлэлцүүлсэн нь бүрэн эрхт БНКАУ-ын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцож байгаагаа НҮБ-ын нэр хүндээр халхлан хаацайлах гэсэн БНХАУ, АНУ-ын илт оролдлого мөн. Дээрхийн тухайд КАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНКАУ-ын Төрийн Зөвлөлийн дарга нөхөр Хенг Самрин, «Кампучийн ямар ч асуудал гэж байхгүй. БНКАУ-ын засгийн газар бол кампучийн ард түмний цорын ганц хууль ёсны, жинэхэн төлөөлөгч мөн Бидэнд нутаг дэвсгэр байна. Бидэнд хүн ам байна. Бидэнд арми байна. Бидэнд хувьсгалт засаг захиргаа, Үндэсний хурал, Үндсэн хууль байна»¹⁷ гэж тов тодорхой мэдэгдсэн билээ.

«Кампучийн асуудал» гэгчийг сэдэгчид БНСВУ-ын хязгаарлагдмал тооны цэрэг БНКАУ-д байгаа явдлыг гүжирдэн дайрах нэг шалтгаан болгодог юм. Үүний тухайд гэвэл Вьетнам улс хөрш зэргэлдээ Кампучид интернационалч тусламж үзүүлэхээ тэнд ямарваа давуу эрх дарх эдлэх, тэгэх тусмаа ямар нэг «дарангуйлал тогтоохыг» эрмэлзсэн хэрэг бишээ.

«Байгууллагын гишүүн улс зэвсэгт довтолгоонд учирвал олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахихад хэрэгтэй арга хэмжээг ганцаараа буюу хамтран авах хөдлөшгүй эрхтэй» гэсэн НҮБ-ын дүрмийн дагуу Кампучийн ард түмний хүсэл зоригийг илэрхийлсэн БНКАУ-ын бүрэн эрхт засгийн газрын хүсэлтээр социалист Вьетнам улс зэвсэгт хүчний зохих тусламж үзүүлж байгаа биш, харин Тайланд болон Хятад нь полпотын дэглэмийн үлдэгдэл хүчийг Тайландын нутагт орогнуулан кампучийн эсрэг халдан түрэмгийлж байгаад л Зүүн өмнөд Азийн тогтворгүй байдлын гол учир шалтгаан, дэвэргээд байгаа «Кампучийн асуудал» гэгчийнх нь мөн чанар оршиж байгаа юм.

¹⁶ «Известия» 23. VIII. 1979.

¹⁷ «Новое время» № 9, 1982.

Ардын хувьсгалынхаа ололтыг хамгаалан бэхжүүлэхийн төлөө кампучийн баатарлаг ард түмний явуулж буй хүнд бэрх, шударга тэмцэл тив дэлхийн дэвшилт улс түмэн, түүний дотор энхийг эрхэмлэгч монголын ард түмний дэмжлэгийг зүй ёсоор хүлээж байгаа юм.

Нөхөр Ю. Цэдэнбал МАХН-ын XVIII их хуралд тавьсан Намын Төв Хорооны тайлан илтгэлдээ: «Полпотын цуст дэглэмийг түлхэн унагаж, улс үндсээ сэргээн мандуулах замд орсон БНКАУ-ыг байгуулсан нь кампучийн ард түмний түүхэн ялалт боллоо. БНКАУ-ын олон улсын байр суурь хэлбэрэлтгүй бэхжиж байгаад сэтгэл ханамжтай байгаагаа бид илэрхийлж байна. Зүүн өмнөд Азийн байдлыг тогтвортой болгох, энэ бүс нутгийн бүх улсын хооронд сайн хөршийн харилцаа тогтооход чиглэсэн Вьетнам, Лаос, Кампучийн засгийн газрын санаачлага чармайлтыг БНМАУ бүрэн дэмжиж байна» гэж цохон тэмдэглэсэн билээ.

НЕОБРАТИМЫЙ РЕВОЛЮЦИОННЫЙ ПРОЦЕСС В КАМПУЧИИ

**(к 5-ю летию Народной революции)
(Резюме)**

Д. Баярху

7 января 1984 года в НРК состоялась торжественная церемония празднования образования республики, 5 лет назад кампучийский народ положил конец правлению пропекинского кровавого режима Пол Пота и Иенг Сари. Борьбу народа против ставленников империализма и гегемонизма возглавила марксистско-ленинская партия, твердо стоящая на позициях пролетарского интернационализма. С образованием НРК начался процесс национального возрождения страны, уверенного движения кампучийского народа по пути строительства основ социалистического общества.

Прошедшие пять лет стали временем всесторонних достижений НРК в деле залечивания ран тяжелой разрушительной войны, преодоления последствий правления полпотовцев, восстановления экономики. Быстрыми темпами развивается сельское хозяйство, устойчивый рост наблюдается в промышленности, набирают мощности основные его отрасли-текстильна каучуковая, энергетическая. Впечатляющие достижения НРК в культурном строительстве, становлении системы здравоохранения.

За последнее время был сделан значительный шаг вперед во всех областях социально-экономического развития. Растет международный авторитет НРК, которому сейчае признали уже около 35 государств и национально-освободительных движений. Достижения НРК во всех областях красноречиво говорят о прочности народной власти.

Но силы империализма и гегемонизма не оставляют своих попыток остановить уверенную поступь Народной Кампучии. Используя своих марионеток-полпотовцев и кхмерскую реакцию, они пытаются повернуть вспять ход развития кампучийской революции, подорвать завоевания народной власти. Полпотовская клика является ныне

главным орудием Пекина в борьбе против стран Индокитая, в его попытках спровоцировать конфликт между странами Индокитая и АСЕАН. В последнее время в Пекине и Вашингтоне развернута шумная кампания против НРК и других стран Индокитая. Marionетки империализма и гегемонизма разглагольствуют о «военных победах» твердят об «освобожденных районах на территории Кампучии».

Однако все эти планы обречены на провал. Бесплодны попытки сил империализма и гегемонизма подорвать завоевания кампучийской революции, повернуть вспять ход развития истории. Кампучийский народ и его народная революционная армия бдительно стоят на страже революционных завоеваний, надежно защищая суверенитет и территориальную целостность НРК.